

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2022 оны 12 дугаар
сарын 9-ний өдөр

Дугаар 449

Улаанбаатар
ХТТ

Төрийн нууцад хамаарах мэдээллийг
ил болгох тухай

Төрийн болон албаны нууцын тухай хуулийн 10.1.5, 10.1.2-т заасныг тус тус үндэслэн Тагнуулын ерөнхий газрын 2022 оны 12 дугаар сарын 8-ны өдрийн ТЭГ01/1470, ТЭГ01/1471 тоот албан бичгээр ирүүлсэн санхүүгийн дагуу Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Төрийн нууцад хамааруулсан "Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн хэрэгжүүлж байгаа "Ил уурхайн олборлолтыг үе шаттайгаар нэмэгдүүлэх, шилдэг технологи нэвтрүүлэх төсөл", "Ил уурхайн аргаар ашиглах боломжгүй нөөцийг дэлд уурхайн аргаар ашиглаж, экспортыг нэмэгдүүлэх төсөл", "Загийн усны хоолойн газрын доорхи усны орд"-оос Тавантолгой нүүрсний уурхай хүртэлх ус хангамжийн шугам хоолойн төслийн ажил, "Богдхан төмөр зам"-ын суурь бүтэц барих төслийн ажил, "Тавантолгой-Гашуунсухайт" чиглэлийн төмөр замын төслийн ажил болон "Тавантолгой-Зүүнбаян" чиглэлийн төмөр замын шугамын доод бүтцийн барилгын ажил, "Тавантолгой-Зүүнбаян" чиглэлийн төмөр замын дээд бүтэц дохиолол холбоо, эрчим хүч, гүүр, хоолойн барилгын ажил, зураг төсөл гүйцэтгэх ажлын холбогдох гэрээг тус тус төрийн нууцаас гаргаж ил болгосугай.

2. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгаланд даалгасугай.

Монгол Улсын Ерөнхий сайд

Л.ОЮУН-ЭРДЭНЭ

Монгол Улсын сайд,
Засгийн газрын Хэрэг
эрхлэх газрын дарга

Д.АМАРБАЯСГАЛАН

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС


ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМ,
"ЭРДЭНЭС ТАВАНТОЛГОЙ" ХК-Д

Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 12 дугаар сарын 9-ний өдрийн хуралдааны 59 дүгээр тэмдэглэлд:

"1.ХЭЛЭЛЦСЭН нь: Төрийн нууцад хамаарах мэдээллийг ил болгох тухай

ШИЙДВЭРЛЭСЭН нь: 1. Төрийн нууцад хамааруулсан "Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн хэрэгжүүлж байгаа "Ил уурхайн олборлолтыг үе шаттайгаар нэмэгдүүлэх, шилдэг технологи нэвтрүүлэх төсөл", "Ил уурхайн аргаар ашиглах боломжгүй нөөцийг далд уурхайн аргаар ашиглаж, экспортыг нэмэгдүүлэх төсөл", "Загийн усны хоолойн газрын доорхи усны орд"-оос Тавантолгой нүүрсний уурхай хүртэлх ус хангамжийн шугам хоолойн төслийн ажил, "Богдхан төмөр зам"-ын суурь бүтэц барих төслийн ажил, "Тавантолгой-Гашуунсухайт" чиглэлийн төмөр замын төслийн ажил болон "Тавантолгой-Зүүнбаян" чиглэлийн төмөр замын шугамын доод бүтцийн барилгын ажил, "Тавантолгой-Зүүнбаян" чиглэлийн төмөр замын дээд бүтэц дохиолол холбоо, эрчим хүч, гүүр, хоолойн барилгын ажил, зураг төсөл гүйцэтгэх ажлын холбогдох гэрээг тус тус төрийн нууцаас гаргаж ил болгох асуудлыг хэлэлцээд тогтоол гаргахаар тогтов.

2. Дээрх гэрээнүүдийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу Авлигатай тэмцэх газарт шилжүүлэн шалгуулах талаар зохих арга хэмжээ авахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгалан, Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт, "Эрдэнэс Тавантолгой" ХК дахь Засгийн газрын онцгой бүрэн эрхт төлөөлөгч Ж.Ганбат нарт даалгав." гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР